



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 17/2023

Аргатай

Хязгаарлалтын дэглэм

цуцлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Шилийн гол 1 дүгээр баг, Энгэр-Ус 2 дугаар багийн нутаг дэвсгэрт гарсан бог малын Мялзан өвчний шинж тэмдэг бүдгэрч эдгэрсэнтэй холбогдуулан 2023 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийг дуустал 14 хоногийн хугацаатай тогтоосон малын гоц халдварт бог малын "Мялзан" өвчний хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Сумын Онцгой комиссоос шуурхай арга хэмжээ авч дээрх бүс нутагт хязгаарлалтын арга хэмжээ авч ажиллаж, халдвар тархаагүй өвчлөл дахин илрээгүй болохыг бүс нутаг дэвсгэрт нутаглаж буй малчдад мэдэгдсүгэй.

3. Малчдыг мэдээллээр хангаж, тухайн бүс нутаг дэвсгэрийн малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, малын гоц халдварт "Мялзан" өвчнөөс сэрэмжилж ажиллах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг багийн Засаг дарга нар, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт болон Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч их эмч (Ц.Батойлэг), малчид ард иргэдэд тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



482301063